**Сумын Засаг даргын Үйл ажиллагааны хөтөлбөр**

**Баянлиг сумын Засаг даргын Тамгын газар**

**2023 оны жилийн эцэс**

| Д/д | Зорилт | Арга хэмжээ | Хэрэгжих хугацаа | Зарцуулсан хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр (сая төгрөг) | Зорилтот түвшин, үр дүнгийн үзүүлэлт | Хүрсэн түвшин, үр дүн | Хэрэгжилтийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| Нэг . “Ковид-19” халдварт цар тахлаас үүдэлтэй эдийн засаг, нийгмийн хүндрэлийг даван туулах бодлогын хүрээнд | | | | | | | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 1.1.. "Ковид-19" халдварт цар тахлаас урьдчилан сэргийлнэ. | 1.1.1.. Сумын нутаг дэвсгэрт коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг "Ковид-19" вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх, салбар дундын зохицуулалт, гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангана. | 2021 - 2024 | -- | | Коронавирусийн халдварын цар тахалтай тэмцэх, хүн амыг "Ковид-19" вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор хүн амын 1 хувийг хамарсан ковидын вакцины тандалт судалгаа хийсэн ба судалгаанд хамрагдагсдын 90 хувь нь ковидын эсрэг вакцины бүрэн тун буюу 3 тунд хамрагдсан. Мөн хавар намрын улиралд улирлын томуугийн өвчлөлийн үеэр амбулаторийн үзлэгт хамрагдсдын дунд ковидын шинжилгээг сэжигтэй 85 тохиолдолд хийхэд өвчлөл бүртгэгдээгүй болно. Гамшгаас хамгаалах алба, мэргэжлийн ангиудын үйл ажиллагааны бэлэн байдлыг хангаж хүний нөөц боловсон хүчний хангалт 100 хувь, эм тариа ороох боох материалын бэлэн байдал нөөц 3 сарын нөөцтэй, урвалж оношлуурын нөөц 80 хувь, нэг удаагийн хувцас хэрэгсэл 2 сарын нөөцтэй, багаж тоног төхөөрөмж 93 хувь, ариутгалын бодис 60 хувь, хоол хүнс 80 хувь, түргэн тусламжийн машины бэлэн байдлаа хангаж ажиллаж байна. | 100% |
| 2 | | 1.1.2.. Хорио цээр, хязгаарлалтын дэглэм тогтоосон үед эрүүл мэндийн салбарын хэмжээний шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, хувийн хамгаалах хэрэгсэл, | 2021 - 2024 | ЭМГ-аас хандив тусламжаар ирсэн. | | Эм эмнэлгийн бараа нийлүүлдэг 2 байгууллагатай гэрээ байгуулан ажилладаг .Өнөөдрийн байдлаар хүний нөөц боловсон хүчний хувьд стандартад заагдсан 4 их эмч, 6 бага эмч, 7 сувилагч, бусад үйлчилгээний 12 нийт 29 ажилтантай бүрэн орон тоогоор, эм ороох боох материалын бэлэн байдал нөөц 3 сарын нөөцтэй, урвалж оношлуурын нөөц 80 хувь, нэг удаагийн хамгаалах хувцас хэрэгсэл 2 сарын нөөцтэй /комбензон 536ш, нүдний шил-226ш, нэг удаагийн халад 1680ш, нэг удаагийн малгай 2260ш, үзлэгийн бээлий 4000ш, нүүрний хаалт 320ш, И-95 маск-214ш, нэг удаагийн маск 3300ш/, багаж тоног төхөөрөмжийн хангалт 93 хувь, ариутгалын | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | оношлуур халдваргүйжүүлэх бодис, эмнэлгийн тоног төхөөрөмжийн хангалтыг тасралтгүй, хомсдол үүсэхээс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нөөцийг бүрдүүлнэ. | | | | бодисын хангалт 60 хувь/ жавилон-8000/, хоол хүнсний хангалт 80 хувь, түргэн тусламжийн машины бүрэн бүтэн байдал хангагдан нэн шаардлагатай дугуй, акумлятор, зэрэг сэлбэг хэрэгсэл тавьж ажиллаж байна. | |
| 3 | | 1.1.3.. Цахим орчин, хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан, иргэдэд коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр эрүүл мэндийн мэдээлэл, зөвлөгөө, зөвлөмжийг хүргэх, сэрэмжлүүлэг мэдээлэлээр хангах ажлыг | 2021 2024 | -- | | Коронавирусийн халдвараас урьчилан сэргийлэх чиглэлээр олон нийтийн арга хэмжээ болон багийн иргэдийн нийтийн хуралд очиж ард иргэдэд, багууд дээр, сургуулийн сурагчдад тухай бүр мэдээ мэдээллийг хүргэж 2 төрлийн 69 ш брошур тарааж, сумын зарын групп-т ковидын тухай мэдээ мэдээллийг тогтмол байршуулж давхардсан тоогоор 500 гаруй иргэнд мэдээлэл хүргэж, ЭМГ-тай аймгийн хэмжээний ковидын талаар хэрэгжүүлж буй ажлын талаарх мэдээллийг 7 хоногт 1 удаа тогтмол солилцон ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | эрчимжүүлэн зохион байгуулна. | | | | | |
| 4 | | 1.1.4.. “Ковид¬¬-19” вирусийн халдварын үеийн орон нутгийн эрсдэлийн үнэлгээг салбар дундын оролцоотой хийж, үр дүнг шийдвэр гаргах үйл ажиллагаанд ашиглах, эрсдэлийг бууруулах цогц арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 2021 2024 | -- | | Байгууллагын хэмжээнд эрсдлийн баг нь эрүүл мэндийн төвийн гадаад орчин, хүний нөөц, эм био бэлдмэл, тоног төхөөрөмж, эмнэлзүй, үйлчлүүлэгч, халдвар хамгаалал гэсэн төрлөөр нийт 57 асуултаар эрсдлийн зэргийг тодорхойлсон. Бага эрсдэлтэй-35, дунд эрсдэлтэй-22 гэж үнэлэгдэн эрсдлийн үнэлгээний дундаж бага эрсдэлтэй байсан. Ковид-19” вирусийн халдварын үеийн эрсдэлийн үнэлгээг 1 удаа хийсэн ба үнэлгээнд хамгийн эрсдэл өндөртэй нь ор дэлгэж ажиллуулахад орны хүрэлцээгүй асуудал байсан буюу эрсдэл багатай нь 1 удаагийн хамгаалах хувцас, халдваргүйтгэлийн бодис, эм тарианы нөөц зэрэг байсан. Эрсдлийн үнэлгээнд тулгуурлан гамшгийн бэлэн байдлыг хангаж эмнэлгийн нөөцөд ЭХЭМҮТ-өөс 20ш ор түмбочекийг нийлүүлэн бүртгэлд авч ажилласан | 100% |
| 5 | | 1.1.5.. Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах бэлэн байдлын төлөвлөгөө боловсруулан хэрэгжүүлэх, тусгаарлах болон эмчлэн тусгаарлах байруудын бэлэн | 2021 2024 | -- | | Ковид-19 халдвараас урьдчилан сэргийлэх бэлэн байдлыг хангах төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 8 заалт боловсруулан хэрэгжүүлж төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай байна. Тусгаарлах өрөөг 4 ортойгоор, эмчлэн тусгаарлах өрөөг 2 өрөөнд 6 ортойгоор байнгын бэлэн байдлыг хангуулахаар зохион байгуулсан. Халдвараас сэргийлэх арга барилд сургах арга хэмжээг сургалт хэлбэрээр явуулж, ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж гар угаах дадал 25 ажилтанд 3 удаа, хамгаалах хувцас өмсөж тайлах дараалалд суралцах дадал 17 ажилтанд 2 удаа, 1 удаагийн бээлий өмсөж тайлж халдвараас сэрийлэх | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байдлыг шуурхай хангаж эмч эмнэлгийн ажилтнуудыг халдвараас сэргийлэх арга барилд сургах ажлын байрны тасралтгүй сургалтыг тогтмол зохион байгуулж ур чадварыг нь дээшлүүлэн аюул эрсдлээс урьдчилан сэргийлж эрүүл мэндээр хохироохгүй байх арга хэмжээг авч ажиллана. | | | | дадалд 28 хүн 1-2 удаа, маск тайлах дадал 28 ажилтан 3 удаа, 58 иргэдийг 1 удаа тус тус хамруулан ур чадварыг нь дээшлүүлэхийн зэрэгцээ халдвараас сэргийлэх арга хэмжээнд сурган ажиллаж байна. Мөн сумын хэмжээнд амьсгалыгн замын эмгэгээс сэргийлж хүндрүүлэх байх чиглэлээр төрөөс явуулж буй бодлогыг дэмжин томуугаас сэргийлэх сайн дурын вакцинд 10 сараас өнөөдрийг хүртэлх хугацаанд эмнэлгийн 29 ажилтан бусад өндөр настан зорилтот бүлгийн иргэдийг, сайн дурын үндсэн дээр хамруулаад байна. | |
| Хоёр. Хүний хөгжлийн бодлогын хүрээнд: | | | | | | | |
| 6 | 2.1.. Эрүүл иргэн -ирээдүйн үнэт зүйл | 2.1.1.. Дархан уул аймгийн Харзтай шүдний эмнэлэгтэй хамтран шүдний эмчилгээний тоног төхөөрөмж, мэргэжлийн эмч бүхий кабинетыг эрүүл мэндийн | 2021 2024 | -- | | Дархан уул аймгийн Харзтай шүдний эмнэлэгтэй гурвалсан гэрээгээр хамтран ажиллаж байна. Шүдний эмчилгээний тоног төхөөрөмж, мэргэжлийн эмч, сувилагч бүхий кабинетыг эрүүл мэндийн төвд нээж ажиллаж байгаа бөгөөд 2023 оны 06, 10 дугаар сард 2 удаа ирж явуулын эмнэлэг ажилласан. Нэг удаа ирэхдээ 7 хоногоор ажиллаж, шүдний эмчилгээ, хиймэл шүдний үйлчилгээгээр нийт 250 хүн жилдээ 500 хүнд шүдний тусламж үйлчилгээ үзүүлж | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | төвд нээх | | | | ажилласан. | |
| 7 | | 2.1.2.. Төсөвт албан байгууллагуудыг ажлын байран дээрээ артерийн даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжийг бий болгон ажиллахад нь дэмжлэг үзүүлэх. | 2021 2024 | -- | | ЕБС, ЗХ-103 дугаар салбар, Ахмадын хороо, Эрүүл мэндийн төвүүд ажлын байран дээрээ артерийн даралт, биеийн жингээ хэмжих, эрүүл мэндээ хамгаалахад зориулсан тоног төхөөрөмжтэй. | 90% |
| 8 | | 2.1.3.. Эм эмнэлгийн хэрэгслийн чанар аюулгүй байдлыг хангаж, эмийн зохистой хэрэглээг төлөвшүүлэх | 2021 2024 | -- | | Зайлшгүй шаардлагатай чанарын баталгаатай эм эмнэлгийн хэрэгслээр тасралтгүй хангаж байна. Өнөөдрийн байдлаар зайлшгүй шаардлагатай эмийн хангалт 85 хувьтай байна. Эмийн зохистой хэрэглээний сургалт, зөвөлгөөг эм олгох бүрт тогтмол хийж сардаа дунджаар 500-550 хүн хамрагдаж байна. Эрүүл мэндийн төвийн эмч мэргэжилтнүүдэд зайлшгүй шаардлагатай эмийн 9 дүгээр жагсаалт. Эмийн жор бичилтын стандартаар сургалт зохион байгуулж сургалтын өмнөх болон дараах сорилыг авч дүгнэсэн. | 90% |
| 9 | | 2.1.4.. Иргэдийн зонхилон тохиолдох халдварт бус | 2021 2024 | -- | | Артерийн даралт ихсэлт, чихрийн шижингийн эрт илрүүлэг үзлэг, хөх умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэх үзлэг шинжилгээг жил бүр хийж байгаа. Эрт илрүүлэг үзлэгт хамрагдах иргэдийн судалгааг | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэг зохион байгуулах замаар нас баралтын түвшинг бууруулах | | | | гарган 2023 онд АГ-ийн эрт илрүүлэгт 1998 хүнээс 951 хүн хамрагдаж шинээр даралт ихсэх өвчтэй 25 хүн шинээр оношлогдож хяналтанд эмчлэгдэж байна. Хамрагдалтын хувь 47.6%, Чихрийн шижингийн эрт илрүүлэгтийн үзлэгт 1265 хүн хамрагдахаас 427 хүн хамрагдаж шинээр оношлогдсон чихрийн шижин байхгүй. Хамрагдалтын хувь 33.8%. Хөх умайн хүзүүний өмөнгийн эрт илрүүлэгт 256 хүн хамрагдахаас 224 хүн хамрагдаж шинжилгээгээр 10 хүн өөрчлөлттэй гарч 6 хүн дараагийн шатлалын эмнэлэгт явж эмчлүүлсэн. Хамрагдалтын хувь -87,5%-тай байна.Нийт нас баралт-15 үүний дотор тархинд цус харвалтаас шалтгаалсан нас баралт -2 бүртгэгдсэн. Элэгний хавдарын үзлэгт 2023 онд 65 хүн хамрагдсан. Ходоодны хорт хавдрын өвчлөл-1 бүртгэгдсэн. Хавдрын нас баралт бүртгэгдээгүй. | |
| 10 | | 2.1.5.. Зонхилон тохиолдох хавдрын эрт илрүүлэг, үзлэгийг чанартай зохион байгуулж, үр дүнг тооцон, үзлэгт хамруулах, тоног төхөөрөмжөөр /Эхо аппарат / хангах. | 2021 2024 | -45,000,000 | | Хөх умайн хүзүүний хавдрын эрт илрүүлэгт 256 хүн хамрагдахаас 224 хүн хамрагдаж шинжилгээгээр 10 хүн өөрчлөлттэй гарч 6 хүн дараагийн шатлалын эмнэлэгт явж эмчлүүлсэн. Элэгний хавдарын үзлэгт 2023 онд 65 хүн хамрагдсан. Ходоодны хорт хавдрын өвчлөл-1 бүртгэгдсэн. Хавдрын нас баралт бүртгэгдээгүй. Сум хөгжүүлэх сангаас тендер зарлаж Медимпекс кампани тендерт шалгаран сум хөгжүүлэх сангаас- 30 сая, байгууллагын төсвөөс 15 сая нийт 45 сая төгрөгийн өртөгтэй X-3 маркийн зөөврийн ЭХО аппаратыг 2023 оны 5 дугаар сард авсан үзлэг оношилгоо хийж байна. | 100% |
| 11 | 2.2.. Засгийн газар, Эрүүл мэндийн | 2.2.1.. Хүн амын хоол тэжээл үндэсний | 2021 2024 | -- | | Хүн амын хоол тэжээл үндэсний хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хоололтыг дэмжин иргэдийн дунд цайг давсгүй хэрэглэх хоолонд давс | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | яамнаас хэрэгжүүлж буй хууль тогтоомж шийдвэрийн хэрэгжилтийг хангах | хөтөлбөрийн хүрээнд иргэдийн зөв зохистой хоололтыг дэмжих сургалт сурталчилгааг тогтмол хийж хүн амын дундах хоол хүнсний далд чихэр тослогыг бууруулан эрсдэлт хүчин зүйлийн нөлөөллийг багасгах замаар илүүдэл жингээс сэргийлэх, бөөр зүрх судасны өвчлөлийг бууруулан үр дүнг тооцох | | | | бага хэрэглэх талаар 122 иргэнд сургалт хийж сургалтын өмнөх сорил тестээр мэдлэгийг үнэлэхэд 82% байсан мэдлэгийн түвшин сургалтын дараа 98 хувь хүртлээ өссөн үр дүнг харуулсан .Энэ жилдээ эрүүл жиндээ аянд нэгдэн 6 сард нээлтээ хийж 405 иргэн хамрагдан эдгээр иргэдээс эргэн мэдээллээр 6 хүн жингээ хаяж хэвийн жиндээ орсон байна сумын хэмжээнд чийрэгжүүлэлтийн өдрийг баг байгууллагаар хувиар гарган явуулах, мөн бүжгийн өдөр 4 дэх өдөрийг товлон явуулж төсөвт байгууллагуудаар манлайлуулан нэг байгууллага 2 бүжиг иргэдэд зааж сургах үйл ажиллагаа зохион байгуулж 5 байгууллага 10 бүжиг иргэдэд зааж сургасан бөгөөд 4 дэх өдөр бүр нийтийн цэнгээнт бүжиг зохион байгуулагдаж хэвшсэн. 2023 онд эрүүл хоололтын талаар иргэдэд 2 удаагийн сургалт зохион байгуулж 122 хүн, эмч мэргэжилтнүүдээс 2 эмч сургалтад хамрагдаж хүн амын дунд хоол хүнсны далд чихэр тослогыг бууруулах, бусад бөөр зүрх судасны эрсдэлт хүчин зүйлүүдийг бууруулах чиглэлээр Мон-Пэйн төсөл хэрэгжүүлэн иргэдийн эрсдэлт хүчин зүйлийн судалгааг авч эхлэн 28 хүнийг хамруулаад байна | |
| 12 | | 2.2.2.. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн иргэдийн хүлээгдэл чирэгдлийг | 2021 2024 | -- | | Эрүүл мэндийн төв нь орон тооны хөтөч ажиллуулан тусламж авахаар ирсэн иргэдэд үйлчлэн ажиллаж байна. Мөн тусламж үйлчилгээний хуваарь гарган батлуулан ажиллаж байна. ЭМД-ын санхүүжилтээр гэрийн сувилахуй, сэргээн засах, өдрийн эмчилгээ, оношилгоо шинжилгээ зэрэг тусламж үйлчилгээг үзүүлж байна. ЭМД-ын хөнгөлттэй жорыг шаардлагатай иргэнд байнга бичиж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бууруулах | | | | | |
| 2.3.. Боловсролын чанар- хөгжлийн тулгуур | | | | | | | |
| 13 | 2.3.. Хүн бүрт чанартай боловсрол эзэмшүүлж, боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, хүүхдэд ээлтэй, эрүүл, аюулгүй орчин бүрдүүлнэ. | 2.3.1.. Өсвөр үе, өрхийн гэрэлт ирээдүй хөтөлбөрийг хэрэгжүүлэх | 2021 2024 | -- | | 1-5 дугаар ангийн сурагчид төслийн хүрээнд “Байгалийн ухаан”-ы хичээлийн туршилтын хэрэглэгдэхүүнийг авсан. Тухайн хэрэглэгдэхүүнийг 1-5 дугаар ангийн 120 сурагч 15 багш хичээл сургалтын үйл ажиллагаандаа хэрэглэж туршилтын хичээлүүдийг амжилттай, хүртээмжтэйгээр зохион байгуулж төсөл хаагдсан. Төслийн гүйцэтгэл 91% тай хэрэгжсэн. | 100% |
| 14 | | 2.3.2. Боловсролын байгууллагуудын хамран сургалтыг 100 хувьд хүргэнэ. | 2021 2023 | -- | | Шатар балансын тоогоор сургуулийн насны 6-10 насны 439 хүүхэд, 11-14 насны 269 хүүхэд, бүгд 699 сурагчид байгаа. 2023-2024 оны хичээлийн жилийн байдлаар хамран сургалт 99.8% -тай байна. Нэг хүүхэд сургууль завсардсан. Өдрөөр 775, дүйцсэн хөтөлбөрт 27 сурагч нийт 802 суралцагчтай, БНОХ-д сураглцагчид 100% хамрагдсан. Сургуулийн өмнөх боловсролд 2023-2024 оны хичээлийн жилд өдрийн бүлэгт 225, хувилбарт сургалтаар 75 нийт 300 хүүхдэд СӨБ олгож байна. 5 настай 80 хүүхэд байгаагаас 74 хүүхэд өдрийн бүлэгт, 6 хүүхэд хувилбарт сургалт буюу явуулын багшийн сургалтад хамрагдаж байна. Хамран сургалтын хувь 88,2 хувьтай байна. | 100% |
| 15 | | 2.3.3. “Сайн багш” хөтөлбөр хэрэгжүүлэх. | 2021 2024 | -- | | Багш нарын мэдээлэл харилцааны технологийг ашиглах чадвар, судалгаа хийх чадвар сайжирсан. Сургуулийн хэмжээнд ур чадварын уралдаан, хамтын хичээл, хөтөлбөр боловсруулах зэрэг ажлуудыг багаар болон ганцаарчилсан хэлбэрээр зохион байгуулж, давхардсан тоогоор 30 багшийг шагнаж | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | урамшуулсан. Хэрэгжилт 100% | |
| 16 | | 2.3.4. “Хүүхдийн амьдрах ухааны төв, хөдөлмөр зуслан“ –д сурагчдыг хамруулна. | 2021 2024 | -- | | 10-11 дүгээр ангийн сурагчдыг “Илгээлтийн эзэд” хөтөлбөр хэрэгжүүлж малчдад 7 хоног туслуулсан. Энэ хөтөлбөр их үр дүнтэй байж сурагчид мал маллах арга ухаанд суралцаж бие даах чадвартай болсон. Сурагчид зуны амралтаар хийж бүтээсэн, сурсан зүйлсээр бүтээлийн үзэсгэлэнг хичээлийн жилийн эхэнд зохион байгуулсан. Нийт 37 сурагч хамрагдсан. | 90% |
| 17 | | 2.3.5. Сургуулийн өмнөх боловсрол, Гашуун дэл бага сургуульд “Авьяас” хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ | 2021 2024 | -- | | Гашуун дэл бага сургуульд Авъяас хөтөлбөр амжилттай хэрэгжиж дуусан ба хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтай. Гашуун дэл бага сургууль 2023 оны 01 дүгээр сард татан буугдсан. | 100% |
| 18 | | 2.3.6.. Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр “Суралцаж байгаа оюутнуудыг боловролын зээлийн сан“-д болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах | 2021 2024 | -1.250. | | Тус сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлгийн тасагт дутагдалтай байгаа Мал зүйчийн орон тоог бий болгох зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуульд мал зүйч мэргэжлээр суралцаж байгаа Д.Мөнхбилгүүнтэй гэрээ байгуулан сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэн ажиллаж байна. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 19 | | 2.3.6.. Орон нутагт дутагдалтай байгаа захиалгат мэргэжлээр "Суралцаж байгаа оюутнуудыг боловролын зээлийн сан"-д болон тэтгэлэгт хөтөлбөрт хамруулах | 2021 - 2024 | 1250 | | Тус сумын Засаг даргын Тамгын газрын Мал эмнэлгийн тасагт дутагдалтай байгаа Мал зүйчийн орон тоог бий болгох зорилгоор Хөдөө аж ахуйн их сургуульд мал зүйч мэргэжлээр суралцаж байгаа Д.Мөнхбилгүүнтэй гэрээ байгуулан сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэн ажиллаж байна. | 90% |
| 20 | | 2.3.7. "Монгол ухаан" хөтөлбөрийг хэрэгжүүлэх. | 2021 - 2024 | - | | Монгол ухаан хөтөлбөрийн хүрээнд 10-11 дүгээр ангийн сурагчдыг "Илгээлтийн эзэд" хөтөлбөр хэрэгжүүлж малчдад 7 хоног туслуулсан. Энэ хөтөлбөр их үр дүнтэй байж сурагчид мал маллах арга ухаанд суралцаж бие даах чадвартай болсон. Мөн түүхэн дурсгалт газар "цагаан агуй", "бичигт хад" 5,8-р ангийн сурагчид аялсан. Бага ангийн сурагчдын дунд шагайн наадгайн тэмцээн болсон. Мөн 9 дүгээр ангийн сурагчид түүхэн дурсгалт газар үзэх аялал зохион байгуулах ажлын хүрээнд Өмнөговь аймгийн Сэврэй сумын сумруу явж тухайн орон нутгийн түүхэн дурсгалт газруудтай танилцаж ирсэн. | 100% |
| 21 | | 2.3.8.. Гашуун дэл бага сургуулийн сурагчдын тоог үе шаттайгаар нэмэгдүүлэх. | 2021 - 2024 | - | | Гашуун дэл бага сургууль нь 2023 оны 01 дүгээр сард татан буугдсан. | 100% |
| 22 | | 2.3.9.. Сурагчдын | 2021 - | Ивээн | | 1-р ангийн сурагчид 100% уншиж, бичиж сурсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | оюуныг хөгжүүлэх, бие даан суралцах, сургалтын хөтөлбөрийг хэрэгжүүлж, уралдаан, тэмцээн, олимпиад зохион байгуулах. Санхүүгийн дэмжлэг үзүүлэх. | 2024 | тэтгэгчээс 500000, сургуулиас 2250000, сумын ЗДТГ-аас 1800000 төгрөг | | байна. Бүх сурагчдын унших хурд ахисан. 1-р ангийн дундаж 35,4, 2-р анги 69,5, 3-р анги 75,9, 4-р анги 97,1, 5-р анги 106 байна. 2-р анги 95 сурагчаас 71 сурагч буюу 74,7%, 3-р анги 70 сурагчаас 51 сурагч буюу 72,8%, 4-р анги 71 сурагчаас 52 сурагч буюу 73,2%, 5-р анги 83 сурагчаас 59 сурагч буюу 71,1% нь болзол хангаж батламж гардан авсан байна. Олон улсын паззлын аймгийн уралдаанд 1 багш хүрэл медаль, 1 сурагч мөнгөн медаль хүртэж улсын уралдаанд амжилттай оролцсон. Энэ хичээлийн жилд Үндэсний бөхий аймгийн аварга шалгаруулах тэмцээн 12б ангийн сурагч Х.Баярсүрэн мөнгө, 8б ангийн сурагч Т.Билэгдэмбэрэл хүрэл медиаль хүртсэн. Мэргэжлийн сумо бөхийн 68 дахь их аварга Hakuho даваажаргалын нэрэмжит өсвөрийн сумо бөхийн аварга шалгаруулах тэмцээнд 6б ангийн сурагч Ц.Хаш-Эрдэнэ тэргүүн байр эзэлсэн. Сургуулийн аварга шалгаруулах 6-7-р ангийн сурагчдын хөл бөмбөгийн тэмцээнд эрэгтэй тэргүүн байранд Б.Энхтуяа багштай 7Б анги дэд байранд Б.Даваацэрэн багштай 6а анги гутгаар байранд Д.Бямбасүрэн багштай 7в анги эмэгтэй тэргүүн байранд Б.Даваацэрэн багштай 6а анги дэд байранд Б.Отгонтуяа багштай 7а анги гутгаар байранд Д.Бямбасүрэн багштай 7в ангиуд тус тус шалгарсан. | |
| 23 | | 2.3.10. “Хос бичигтэн”, “Англи хэл”, “Робокон-Баянхонгор”, “ном”, “аав ээж би” дэд | 2021 2024 | -- | | Хос бичигтэн хөтөлбөрийн хэрэгжилт 100 хувь, Англи хэл хөтөлбөр хэрэгжих хугацаанд хамрагдсан сурагчдын тоо давхардсан байдлаар 500 гаруй байсан. Хөтөлбөрийн хэрэгжилт 90% “Робокон”-ы клубт нийт давхардсан тоогоор 36 сурагч хамрагдаж 4 жилд 16 сурагч аймгийн уралдаанд амжилттай | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх. | | | | оролцсон. Хөтөлбөрийн хэрэгжилт 75%-тай хэрэгжсэн. Ном хөтөлбөрийн хэрэгжилт 90%-тай байсан ба тус хөтөлбөрүүд бүгд хэрэгжиж дуссан. | |
| 24 | | 2.3.11. Номын сангийн баяжилт хийх | 2021 2024 | -913,000 | | Сурагчдын хичээлээс гадуурах унших зохиол өгүүллэг, үлгэр, домог, роман, үргэлжилсэн үгийн зохиолын ном 913.000₮ үнэ бүхий 54ш номоор тус тус баяжигдсан.Гашуундэлийн бага сургуулийн номын сангаас үлгэрийн болон зохиолын 120ш ном хүлээн авсан. Нийт 174 ширхэг номоор баяжилт хийгдсэн. | 100% |
| 25 | | 2.3.12.. Боловсролын чанарын үнэлгээг дээшлүүлж, суралцагчийн хөгжлийн хэрэгцээ шаардлагыг хангасан бүтээлч багшийг бий болгож, чадварлаг багш арга хэмжээг хэрэгжүүлж шагнаж урамшуулна. | 2021 2024 | -- | | Жил бүр суралцахуйн хөгжлийн багаар “Багшлахад учир бий-1,2” арга хэмжээг зохион байгуулж эхний 3 байрыг шалгаруулж нийтдээ 34 багшийг шагнаж урамшуулсан. | 100% |
| 26 | | 2.3.13. Насан туршийн боловсролын хүртээмжийг | 2021 2024 | -- | | Хүүхэд хүмүүжлийн эерэг арга сургалтыг 764 гаран эцэг эхчүүдэд, санхүүгийн боловсролыг 46 залуучуудад, харилцаа хандлагын сургалтыг 4 удаа 78 иргэдэд хийсэн. Санхүүгийн боловсрол 9 удаа 212 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | нэмэгдүүлж, цахим, сургалтыг хөгжүүлж, иргэдийн тасралтгүй боловсролыг дээшлүүлнэ. | | | | иргэнд, гэр бүлийн боловсрол 16 удаа 215 иргэнд, гоо зүйн боловсрол 3 удаа 112 иргэнд, ёс суртахуун, төлөвшлийн сургалтыг 15 удаа 220 иргэнд, иргэний боловсрол 2 удаа 54 иргэнд, амьдрах ухааны боловсрол 3 удаа 13 иргэнд, мэдээлэл харилцаа 2 удаа 40 иргэнд, монгол бичиг 16 удаа 298 иргэнд, өрхийн хөгжил арга хэмжээ 9 удаа 156 иргэнд нийт 2208 иргэнд 68 удаагийн сургалт мэдээллийн арга хэмжээ зохион байгуулсан. | |
| 27 | | 2.3.14. Сурагчдын сэтгэн бодох чадварыг сайжруулах чиглэлээр Ерөнхий боловсролын сургуульд “Соробан сампин”-гийн иж бүрэн танхимыг байгуулах. | 2021 2024 | -- | | Соробан сампины захирал Н.Мөнхтуяатай уулзаж 2022 оны намар сургагч багш бэлдэж, кабинет байгуулж 2022- 2023 оны хичээлийн жилд С.Жаргалчимэг багш “Соробан сампин”-гийн сургалыг 5-10 насны нийт 32 сурагчдад зохион байгуулж Basic B түвшин 12 хүүхэд, EA түвшин 18 хүүхэд, EB түвшин 2 хүүхэд төгссөн. Улаанбаатар хотод болсон Үндэсний аврага шалгаруулах тэмцээнд 13 сурагчыг бэлтгэн амжилттай оролцсон. | 100% |
| 2.4.. Иргэдийн нийгмийн баталгааг хангах. | | | | | | | |
| 28 | 2.4.. Иргэдийн нийгмийн баталгааг хангах. | 2.4.1. Малчид, хувиараа хөдөлмөр эрхлэгчдийг даатгалын үйлчилгээнд хамруулж, нийгмийн | 2021 2024 | -- | | 2023 онд 221 малчин, 5 хувиараа хөдөлмөр эрхлэгч иргэн Сайн дурын даатгалд даатгуулсан. Жилийн эцсийн байдлаар 199312.39 мян төгрөгний шимтгэлийн орлого төлөвлөгөөтэйгөөс 271 даатгуулагч сайн дурын даатгалд хамрагдаж 173730.84 мян төгрөгний шимтгэлийн орлого төвлөрүүлж 87% иар биелүүлж ажиллаа. | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | баталгааг хангана. | | | | | | |
| 29 | | 2.4.2.. Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн ажлын байрыг нэмэгдүүлэх | 2021 2024 | -- | | 2023 оны 10 дугаар сарын 11-ний өдөр зохион байгуулагдсан “Баялаг бүтээгчид” үзэсгэлэн худалдаанд хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг хамруулан тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг сурталчлах, худалдан борлуулах үйл ажиллагааг зохион байгуулсан. Нийт 5 хөгжлийн бэрхшээлтэй гишүүнтэй өрх өөрийн тариалсан ногоо, боловсруулсан цагаан идээгээр үзэсгэлэн гаргаж худалдан борлуулсан. Төрийн байгууллагуудад Хөдөлмөрийн тухай хуулийн 144 дүгээр зүйлийн хэрэгжилтэд үзлэг зохион байгуулахад Сумын нийт байгууллагуудаас Засаг даргын Тамгын газар, Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль нь 25-аас дээш ажилтантай байна. Ерөнхий боловсролын сургуульд 2 хөгжлийн бэрхшээлтэй хүн, 1 хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүн, Засаг даргын Тамгын гаарт 1 хүн, Эрүүл мэндийн төвд хөгжлийн бэрхшээлтэй иргэн ажилладаггүй гэсэн үзүүлэлттэй байна. | | 100% |
| 30 | | 2.4.3.. Ажилтай орлогтой өрхийн тоог нэмэгдүүлж 25-аас доошгүй иргэн байнгын болон түр ажлын байраар хангагдах. | 2021 2024 | -- | | Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 10 иргэн, Хоршоог хөгжүүлэх санд 2 иргэн 1 хоршоо, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн төсөл хөтөлбөрт 3 иргэн тус тус хамрагдаж 19 иргэн байнгын ажлын байраар 9 иргэн улирлын чанартай ажлын байраар хангагдсан. | | 100% |
| 31 | | 2.4.4. Ахмадын | 2021 | -- | | Ахмадын зөвлөх үйлчилгээг Хүүхдийн цэцэрлэгт | | 70% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | зөвлөх үйлчилгээг хэрэгжүүлж тухайн ахмад настангуудын өрхийн орлогыг нэмэгдүүлэх | 2024 | | | хэрэгжүүлж, Цэцэрлэгт ажиллаж байсан ахмад настнуудаас урьж ярилцлага өрнүүлэн тэдний сайн туршлага санал бодлыг сонсон ажилласан. | |
| 32 | | 2.4.5.. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 2021 2024 | -- | | Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих аймгийн дэд хөтөлбөрийн хүрээнд Малчин өрхийг малжуулах арга хэмжээнд 5 өрх 10 иргэн, Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд 1, иргэн, аж ахуй эрхлэгчид олгох санхүүгийн дэмжлэгт 2 иргэн хамрагдсан. | 100% |
| 33 | | 2.4.6. Зорилтот бүлгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжих | 2021 2024 | -- | | Хувиараа хөдөлмөр эрхлэгч 1 ахмад настныг Ахмадын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих арга хэмжээнд, Малгүй болон хонин толгойд шилжүүлснээр 200-с доош толгой малтай 5 малчин өрхийг малжуулах арга хэмжээнд тус тус хамруулж хөдөлмөр эрхлэлтийг дэмжсэн. | 90% |
| 34 | | 2.4.7. Хамтарсан багийн үйл ажиллагааг эрчимжүүлж, гишүүдийг чадавхижуулахан Хүүхэд хамгааллыг сайжруулж, гэр бүлийн тогтвортой байдлыг хангаж, | 2021 2024 | -- | | Аймгийн ГБХЗХГ-с 2023 оны 03 дугаар сарын 24-28-ны өдрүүдэд Улаанбаатар олон улсын их сургуулийн доктор багш Р.Оюун-Эрдэнэ, Ө.Байгаль нарын “Нийгэм сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх” сургалтад Хамтарсан багийн гишүүд хамрагдан хүчирхийлэл үйлдэгчтэй хэрхэн харьцах талаар мэдлэг, туршлага хуримтлуулсан. Аймгийн ГБХЗХГ-с “Хамтарсан багийн гишүүдийг чадавхжуулах нь” сургалтыг 2023 оны 09 дүгээр сарын 25,26-ны өдрүүдэд зохион байгуулж Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Сургуулийн нийгмийн ажилтан, Эрүүл мэндийн нийгмийн ажилтан, Хэсгийн төлөөлөгч гэсэн гишүүд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гэр бүлийн гишүүдэд болон хүүхдэд ээлтэй бодлого хэрэгжүүлж хүний хөгжил, хамгааллыг сайжруулах. | | | | сургалтад хамрагдсан. Сургалтын үр дүнд хамтарсан багийн гишүүдийн чиг үүрэг болон хамтарч ажиллах арга зүйд суралцсан. Аймгийн ГБХЗХГ Цагдаагийн газартай хамтран “Харилцан туршлага солилцъё-хамтдаа хөгжье” бүсийн туршлага солилцох уулзалт зохион байгуулж Нийгмийн бодлогын мэргэжилтэн, Сургуулийн сэтгэл зүйч, Халамжийн мэргэжилтэн, Цэцэрлэгийн арга зүйч, Хэсгийн төлөөлөгч гэсэн 5 хүний бүрэлдэхүүнтэйгээр Жинст сумд бүсийн уулзалтад оролцсон.Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 5 кейс нээн Хамтарсан багаараа төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 90 хувьтай. Өмнөх онтой харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл энэ онд 16.7%-иар буурсан байна. ЕБС болон цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг, Хамтарсан багийн гишүүд хамтран сумын хэмжээний Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон зорилтот өрхүүдийн дэлгэрэнгүй судалгаа түүн дээр нэмээд 30 гаруй төрлийн судалгааг нэгтгэн гаргасан. Эрсдэлт нөхцөлд байгаа айл өрх болон хүүхдийн судалгааг дэлгэрэнгүйгээр гарган үүн дээр тулгуурлан гэр бүлийн 3 кейс, хүүхэд хамгааллын үйлчилгээтэй холбоотой 3 кейс, нийт 6 кейс нээн ажилласан. Хамтарсан багийн гишүүд болон Цэцэрлэгийн хүүхэд хамгааллын баг хамтран эрсдэлтэй байх магадлалтай хараа хяналт сул хүүхдүүдийн гэрт очин нөхцөл байдлын үнэлгээ хийж үр дүнг хэлэлцсэн. | |
| 35 | | 2.4.8. Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг | 2021 2024 | -- | | Хүн амын удмын санд учирч болзошгүй сөрөг нөлөөллийг арилгах, урьдчилан сэргийлэх ажлын хүрээнд “Угийн бичиг хөтлөлтийн программ”-ыг иргэд олон нийтэд сургалт мэдээлэл хийн сурталчлан | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | арилгах, урьдчилан сэргийлэх | | | | таниулж ажилласан. Сумын 1 дүгээр багийн иргэдийн нийтийн хуралд 55 хүнд, 5 дугаар багийн иргэдийн нийтийн хуралд 74 хүнд сургалт мэдээлэл хийж, угийн бичиг хөтлөх аргачлал, ач холбогдлын талаар таниулж ажилласан. | |
| 36 | | 2.4.9.. Угийн бичиг хөтлөх аян зохион байгуулах | 2021 2024 | -- | | Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлүүд болон багийн Засаг дарга нартай хамтран төрийн албан хаагчид болон ард иргэдийг угийн бичиг хөтлөх уриалга гарган, угийн бичиг хөтлөх арга зүйн талаар багийн иргэдийн нийтийн хурал болон албан байгууллагуудад сургалт хийж ажилласан.Сургалтад 253 хүн хамрагдсан. Уриалгын хүрээнд ЗДТГ 28-16 албан хаагч буюу 57.8%, ЕБС 74-27 албан хаагч буюу 36,4%, Эрүүл мэндийн төв нь 31-12 албан хаагч буюу 38.7%, СӨБ 21-12 албан хаагч буюу 57,1%, Соёлын төв 6-2 албан хаагч буюу 33.3% нь угийн бичиг хөтөлсөн үр дүнтэй байна. | 70% |
| 37 | | 2.4.10. Иргэдэд эрүүл аж төрөх дадал хэвшилд сургах, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох | 2021 2024 | -- | | Улсын хэмжээнд зохион байгуулж буй “Энэ жилдээ-эрүүл жиндээ” аянд нэгдэж, аяны хүрээнд албан байгууллага ард иргэд 11 цагаас ажлын байрны дасгал хөдөлгөөн, шугаман бүжгийг хийж хэвшсэн. Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын сургууль, Хүүхдийн цэцэрлэгтэй хамтран эрүүл зөв хооллолтыг хэвшүүлэх хоолны амталгаа зохион байгуулж, хоолны жорыг бэлтгэн хоолны хамт байршуулсан. Эрүүл мэндийн төвийн хамт олон цусны даралт хэмжих, Биеийн жингийн индекс тодорхойлох, Эрүүл жин тодорхойлох өртөөчилсөн үзлэг хийж 58 хүнд эрүүл мэндийн үйлчилгээг үзүүлсэн. Пүрэв гариг бүрийг бүжгийн өдөр болгон чалленж зарлан тогтмол үйл ажиллагаа явуулж байна. Нийт давхардсан | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тоогоор 834 иргэн хамрагдсан. | |
| 38 | | 2.4.11.. Нохой, муур устгалын ажлыг жил бүр зохион байгуулж, тусгай зөвшөөрөл бүхий иргэнийг бэлтгэх | 2021 - 2024 | Нийт 2616500 төгрөг, 175 литр шатахуун зарцуулсан. | | хавар намрын устгалаар Анчин О.Эрдэнэбатыг хөлслөн нийт 108 нохой, 4 муур устгасан. Нийт 2616500 төгрөг, 175 литр шатахуун зарцуулсан. | 100% |
| 39 | 2.5.. Спорт, соёлын салбарын үйл ажиллагааг эрчимжүүлэх. | 2.5.1.. Сумын нийт ард иргэдийн дунд соёл урлаг, спортын арга хэмжээг зохион байгуулах. | 2021 - 2024 | - | | Төрийн ба төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, ард иргэдтэй хамтран 142 соёл урлагийн үйл ажиллагааг давхардсан тоогоор 17200 ард иргэд, хүүхэд залуучуудад хүргэж үйлчилсэн. | 100% |
| 40 | | 2.5.2.. Соёлын биет ба биет бус өв, түүх соёлын дурсгалын хадгалалт хамгаалалтыг сайжруулах, ард иргэдэд сурталчилан таниулах. | 2021 - 2024 | - | | Сумын хамгаалалтанд байдаг ТСҮХД 27 газрыг Соёлын төвийн дарга, багийн Засаг дарга, малчидтай гурвалсан гэрээг 100 хувь хийсэн. Хариуцан хамгаалж байгаа малчдыг соёлын үзвэр үйлчилгээнд үнэ төлбөргүй оруулж урамшуулан ажилласан..<br><br>Хавсралт : 1 зураг | 100% |
| 41 | | 2.5.3.. Соёлын бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан иргэдийг соён | 2021 - 2024 | - | | Бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээний хүрээнд төрийн ба төрийн бус байгууллага аж ахуйн нэгж, ард иргэдтэй хамтран 142 соёл урлагийн үйл ажиллагааг давхардсан тоогоор 17200 ард иргэд, | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гэгээрүүлж, хандлагыг өөрчилж “Бүх нийтийн соёлын боловсрол” арга хэмжээг хэрэгжүүлэх. | | | | хүүхэд залуучуудад хүргэж үйлчилсэн. | |
| 42 | | 2.5.4.. Урлаг соёлын чанар хүртээмжийг дээшлүүлж, үйл ажиллагаа явуулах орчин нөхцөл сайжруулах. | 2021-2024 | 70 сая | | Шинэ соёлын төвд шаардлагатай байгаа техник хэрэгсэл болон тохижилтын санхүүжилтыг Аймгийн ОНХС-аас 40 сая, сумын ОНХС-аас 30 сая нийт 70 сая төгрөгийг санхүүжилт шийдвэрлүүлж тайзны хөшиг, техник хэрэгсэл болон бусад тавилга хэрэгслийг техникийн тодорхойлолтын дагуу хүлээн авч ашиглаж байна. | 100% |
| 43 | | 2.5.5.. Иргэдийн ном унших дадал хэвшлийг нэмэгдүүлж, номын сан болон орон нутаг судлах танхимын үйл ажиллагааг сайжруулах | 2021-2024 | - | | Аймгийн номын сантай гэрээ хийж 6 удаа 120 ширхэг шинэ ном авч номын фондоо баяжуулан уншигчдад үйлчилсэн.Татгалзлын бүртгэлийг хөтлөж 25 номыг бүртгэж уншигчдад олж өгч уншуулсан.Соёлын өв, музейн бүртгэл мэдээллийн ажилтантай болсноор ОНСТ-ын үйл ажиллагаа сайжирсан. Шинээр үзмэрийн 3 хорготой болсон бөгөөд 211 үзмэрийг шинээр дэлгэн СӨБ болон ЕБС-ын 332 хүүхдэд үзүүлсэн. | 100% |
| 44 | | 2.5.6.. Бүх нийтийн биеийн тамирыг бүх талаар дэмжин холбогдох хүмүүстэй | 2021-2024 | 52,870,000 | | Бүх нийтийн биеийн тамир спортыг хөгжүүлэх, иргэдийг идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр хичээллэхийг дэмжих зорилгоор Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр “Фитнесийн иж бүрэн тоног төхөөрөмж” худалдан авч тусгай өрөө гарган тохижуулсан. Фитнес төв нээгдсэнээс хойш 23 хүн | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамтран ажиллах | | | | идэвхтэй дасгал хөдөлгөөнөөр тасралтгүй хичээллэсэн байна. | |
| 45 | | 2.5.7.. Үндэсний спортын холбоодуудтай байнга хамтран ажиллаж, бүх талаар дэмжин ажиллах | 2021 2024 | -- | | Үндэсний бөхийн холбоо, Уяачдын холбоо, Сурын холбоо, Шагайн харваан холбоодуудтай байнга хамтран ажиллаж тэднийг дэмжих зорилгоор хуучин Соёлын төвд өрөө гарган бэлтгэл сургуулилтаа тасралтгүй явуулах боломж нөхцөлөөр хангасан. Сур, шагайн харваан холбоодын хүмүүсийг тэмцээн уралдаанд явахад нь замын зардлаар хангах зэргээр дэмжиж ажилласан. | 100% |
| Гурав.. Эдийн засгийн бодлогын хүрээнд: | | | | | | | |
| 46 | 3.1.. Газар тариалангийн салбарын үйл ажилагааг дэмжиж, тариалалт, ургац хураалтыг нэмэгдүүлнэ. | 3.1.1. Төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ хөтөлбөрийн хүрээнд хийгдсэн ажлын үр дүнг тооцож цаашид төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтарч хэрэгжүүлэх. | 2021 2024 | -- | | Төмс хүнсний ногоо хөтөлбөр ажилттай хэрэгжиж хөтөлбөрийн биелэлт 92 хувьтай. Тус сумын хувьд энэ жил 6,8 га талбайд төмс, 7,34 га талбайд хүнсний ногоо тариалсан. | 90% |
| 47 | | 3.1.2. Дархан хотын ургамал судлалын хүрээлэнтэй хамтран нутгийн арвайн дээжийг сорт судалгаанд | 2021 2024 | -- | | Тус сумд тариалан эрхэлдэг Шижир Арвайн эрдэнэ хоршоо нь Дархан хотын ургамал судлалын хүрээлэнд “Хөх арвайн” дээж явуулж сорт судалгаанд хамруулан, био химийн найрлагыг тогтоолгож тариалалтаа явуулж болно гэсэн хариуг авч жил бүр Хөх арвайн тариалалтаа эрхэлж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хамруулж био химийн найрлага тогтоож ,ургац нэмэгдүүлэх бордоог турших улмаар Лигийн гол-арвайн брэнд бүтээгдэхүүнтэй болох. | | | | | |
| 48 | | 3.1.3.. Лигийн голын услалтын системыг бүрэн хүчин чадлаар нь ашиглаж хөх арвай, төмс, хүнсний ногоо тариалалтыг нэмэгдүүлж, хамгаалалтын тор хайс хашаажуулах хиймэл нуурын нөөцийг хангах | 2021 2024 | -- | | Лигийн голын тариаланчид нь хиймэл нуурын услалтаар тариалалтаа эрхэлдэг бөгөөд тус сумын хувьд энэ жил 1 иргэн 1 ААН хөх арвай тариалж 600кг арвайг хураан авсан байна. 6,8 га талбайд төмс, 7,34 га талбайд хүнсний ногоо, 5,4 га талбайд тэжээлийн ургамал тариалсан байна. Хиймэл нуур нь хамгааллатын тор, хашаатай. | 100% |
| 49 | | 3.1.4.. Газар тариалан эрхлэгчдийг дэмжих, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах зээлийн | 2021 2024 | -45 сая | | Тус сумын тариалан эрхлэгч Ахан дүүсийн арвин ургац хоршоо нь Хоршоо хөгжүүлэх сангаас 45 сая төгрөгийн зээл тусламжид хамрагдаж 1 хүлэмж шинээр барьж тариалалтыг эрчимжүүлэн ажиллаж байна.Тариалан эрхлэгчдэд одоогийн байдлаар трактор 1ш, анжис 1ш, төмс үрлэгч 1ш, хамарлагчыг ашиглан тариалан эрхлэлтээ хийж байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | бодлогоор дэмжих | | | | | |
| 50 | | 3.1.5.. Стандартын шаардлага хангасан хүлэмж, зоорийн тоог нэмэгдүүлэн ашиглалтыг сайжруулна. | 2021 - 2024 | 45 сая | | Сумын хэмжээнд стандарт шаардлага хангасан 8 хүлэмжид тариалалтыг хийж байна.2023 онд газар тариалан эрхлэгчдийг дэмжих зээл тусламжид 1 ААН хамрагдаж 1 зоорийг шинээр барьж тариалалт эрхэлж байна. | 100% |
| 51 | | 3.1.6. Газар тариалангийн услалтын системийг сайжруулах зорилгоор хос нуур бий болгож, хөдөөгийн багуудад газар тариалангийн бүсүүд байгуулан БАХ-үүдийн малын тэжээл тариалах нөхцөл боломжийг бүрдүүлэн тоног төхөөрөмжөөр хангана. | 2021 - 2024 | - | | Тус сум нь 100:100 харьцаатай хиймэл нуурыг Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд сэргээн засварлаж Хатансуудал 5 дугаар багийн нутагт төмс, хүнсний ногоо болон малын тэжээлийг тариалж байна. | 90% |
| 52 | 3.2. Мал эмнэлгийн аж | 3.2.1. Малын халдварт, гоц | 2021 - 2024 | Шатахуун 1,600,000 | | Сумын хэмжээнд 81022 малыг халдварт өвчнөөс урьчилан сэргийлэх вакцинд хамруулахаар Мал | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ахуйн нэгжийг чадавхжуулж, үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэн эрүүл бүс статусаа бататгана. | халдварт, шимэгчтэх өвчинтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх, үйл ажиллагааг хэрэгжүүлж эрүүл бүс статусаа бататгана. | | | | эмнэлгийн тасгийн тархвар зүйч А.Элдэв-Очир мал эмнэлгийн нэгдсэн системд төлөвлөж оруулсан үүний дагуу багийн Засаг дарга нар айл өрхүүдээр зар хүргэх багийн цахим грүппэд байршуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Баянлиг түмэн тэмээ мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 17686 толгой мал хамруулахаас 17367 толгой мал хамруулж гүйцэтгэл 98.20%, Баянлиг буянт сүрэг мал эмнэлэг 6 төрлийн вакцинд 27173 толгой мал хамруулахаас 26130 толгой мал хамруулж гүйцэтгэл 96.16%, Хар ботго мал эмнэлэг 8 төрлийн вакцинд 36163 толгой мал хамруулахаас 35932 толгой мал хамруулж гүйцэтгэл 99.36%-тай байна. Сумын хэмжээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд 167757 толгой мал хамруулахаас 163290 толгой мал хамрагдаж гүйцэтгэл 97.34%тай хэрэгжүүлж ажилласан байна. Мөн гоц халдварт шүлхий өвчний вакциныг хавар, намрын давтамжтайгаар 2 удаа хийж гүйцэтгэсэн. | |
| 53 | | 3.2.2.. Малын шилжилт хөдөлгөөн болон малын гаралтай бүтээгдэхүүнд тавих хяналтыг сайжруулах | 2021 2024 | -- | | Мал амьтны шилжилт хөдөлгөөнийг хориглосон аймгийн Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 20 өдрийн А/36 дугаар тоот захирамж, сумын Засаг даргын 2023 оны 01 дүгээр сарын 31 өдрийн А/17 дугаар Захирамжийг тус тус хэрэгжүүлж ажилласан. Мал мах-2023 аяны хүрээнд сумын Хэсгийн төлөөлөгч, мал эмнэлгийн улсын байцаагч нар хамтран ажилласан. Өвлийн идэшний цаг болсон тул мал нядалгааны газруудад очиж хяналт шалгалтыг хийж гүйцэтгэж мөн мэдээ мэдээллээр хангаж ажилласан. Галзуу өвчнөөс урьдчилан сэргийлэх, бог малын мялзан өвчний талаар 3 өрхөд тандалтын судалгаа хийж ажилласан. Цагаан ямаат хоршооны малчдад мал эмнэлгийн үйлчилгээ, МЭНС-2.0, | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | цагийн мэдээллийн талаар 02 дугаар сарын 06 өдөр Малын эмч Г.Ерөөлт, тархвар зүйч А.Элдэв-Очирын хамт оролцож 110 гаруй малчдад мэдээллийг өгч ажилласан. Малчид, төлчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж Мал эмнэлэг, хөдөө аж ахуйн тасгийн мэдээллийг 250 гаруй малчдад хүргэсэн. Монгол ви ти нет олон улсын байгууллагатай хамтран 05-р сарын 07нд уяачид, малчдад зориулсан Шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулж эмийн худалдан борлуулалт хийгдсэн. | |
| 54 | | 3.2.3. Мал эмнэлгийн бэлэн байдлыг хангах, шаардлагатай эм бэлдмэлийн нөөц бүрдүүлнэ. | 2021 2024 | -- | | Мал эмнэлгийн үйлчилгээнд зориулж ариутгалын бодис, 200 кг хлорын шохой, нэг удаагийн мал эмнэлгийн хувцас 10 ширхэгийг нөөцөд бүрдүүлэн мал эмнэлгийн үйлчилгээнд ашиглаж байна. Нөөцийн хангалт 95 хувьтай. | 100% |
| 55 | 3.3.. Малын чанар ашиг шимийг сайжруулах | 3.3.1. Малын чанар, ашиг шимийг сайжруулах малын тоог чанарт шилжүүлж “Монгол мал-2”, “Монгол малчин”, “Шинэ хөдөө” үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. | 2021 2024 | - | | Монгол мал хөтөлбөр 2011-2021 онуудад 2 үе шаттайгаар хэрэгжиж дууссан. Хөтөлбөрийн хэрэгжилт 90 хувьтай. Монгол малчин хөтөлбөрийн хүрээд 2023 оны 03 дугаар сарын 13-ны өдөр Малчид төлчдийн зөвлөгөөнийг зохион байгуулж 275 малчин хамрагдсан. Зөвлөгөөнд төрийн байгууллагын удирдлагууд холбогдох мэргэжилтнүүд оролцож сургалт мэдээлэл хийсэн.Зөвлөгөөний үеэр гар бөмбөг, шагай наадгайн тэмцээнүүдийг зохион байгуулсан. Шинэ хөдөө үндэсний хөтөлбөрийн хүрээнд Хөдөө аж ахуйн кластер төслийг хэрэгжүүлж төслийн хүрээнд ингэний сүүний үйлдвэр байгуулах, газар тариалангийн тоног төхөөрөмжийн тоог нэмэгдүүлэх ажлууд хийгдсэн. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 56 | | 3.3.2. Хөдөө аж ахуйн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг хөгжүүлж, малын гаралтай бүтээгдэхүүний экспорт болон үйлдвэрлэл эрхлэгчдийг дэмжиж, ажлын байр нэмэгдүүлэн, бренд бүтээгдэхүүн бий болгоно. | 2021-2024 | - | | Малаас гаралтай түүхий эдийг боловсруулж зах зээлд худалдан борлуулах үүднээс тус сумын иргэн Ц.Ариунаа хөдөлмөр халамж үйлчилгээний төвөөс зарласан Ахмадын ажлын байрыг дэмжих арга хэмжээний хөтөлбөрт хамрагдаж 3 сая төгрөгний тусламж авч хөдөлмөр эрхэлж байна. Мөн Их халбагант ХХК ингэний сүү цагаан идээгээр төрөл бүрийн бүтээгдэхүүн боловсруулж намрын ногоон өдрүүд “Баянхонгорын бренд бүтээгдэхүүн шалгаруулах” болзолт уралдаанд оролцож импортыг орлосон, экспорт руу чиглэсэн бүтээгдэхүүнээр “Дэд” байр эзэлсэн. | 100% |
| 57 | 3.4.. Үйлдвэржилтийн бодлогын судалгаан дээр үндэслэн сумын үйлдвэржилтийн бодлогыг тодорхойлж зах зээлийг судлах, цаашид эдийн засгийн үр өгөөжийг нэмэгдүүлэх. | 3.4.1. Үйлдвэржилтийн бодлоготой уялдуулж орон нутгийн чиглэлийг тодорхойлж жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгчдэд зээл олгож ажлын байрыг нэмэгдүүлэх. | 2021-2024 | 120,280,000 | | Хоршоо хөгжүүлэх сангаас Ахандуусийн арвин ургац хоршоо 45,280,000 төгрөгийн малын тэжээлийн ургамал, төмс хүнсний ногоо, нарийн ногоо, хүлэмж, Б.Долгорсүрэн “Хэвлэлийн цех” 35,000,000 сая төгрөг, С.Амарсанаа “Төмөр хийц” 10,000,000 төгрөг, Ц.Цэндцэвээн “Хоёрдогч түүхий эд боловсруулах төсөл, 30,000,000 төгрөгийн зээл олгож үйл ажиллагааг дэмжин 4 төрлийн ажлын байруудыг бий болгож ажилласан.<br><br>Хавсралт : 4 зураг | 100% |
| 58 | | 3.4.2.. Ингэний сүү хуурайшуулах үйлдвэр | 2021-2024 | - | | Тус сумын иргэн Ц.Ариунаа нь хөдөлмөр халамж үйлчилгээний төвөөс зарласан Ахмадын ажлын байрыг дэмжих арга хэмжээний хөтөлбөрт хамрагдаж | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгуулах мөн арьс шир, нэхий боловсруулах анхан шатны цехийн үйл ажиллагааг сайжруулан ажиллуулах | | | | 3 сая төгрөгний тусламж авч Арьс шир, нэхий боловсруулах анхан шатны тоног төхөөрөмж болох элдүүрийн машин авч малаас гаралтай түүхий эд болох нэхий, хурганы арьсыг боловсруулж хурган болон үзүүрсгэн дээл, нэхий богц, ямаан дах зэргийг зах зээлд худалдан борлуулж байна.Ингэний фермертэй болох бэлтгэл ажил явагдаж байна. Ингэний сүү хуурайшуулах үйлдвэрийг Баянхонгор аймагт байгуулахаар болж тоног төхөөрөмж бэлэн болсон. | |
| 59 | 3.5. Санхүү эдийн засгийн хүндрэлийг тооцож, эдийн засгийг тогтвортой байлгахад анхаарна. | 3.5.1. Татварын хууль тогтоомжийг сурталчилан хэрэгжилтэд хяналт тавих, улс орон нутгийн төсвийн орлогыг татварын нэр төрөл бүрээр жигд хангаж биелүүлэх | 2021 2024 | -- | | ААНОАТ-6102.6 мянган төгрөг, НӨАТ-2700.6 мянган төгрөг, агаарын бохирдол-2009.4 мянган төгрөг нийт 10802.6 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн. Орон нутгийн орлогын жилийн төлөвлөгөө 501414500, гүйцэтгэл 488407900, биелэлт 97.4%-ийн биелэлттэй байна. Багуудын ИНХ-д 8 удаа давхардсан тоогоор 520 иргэнд татварын хууль тогтоомжийн мэдээлэл өгч төлөвлөгөөг ЗДТГ-ын даргаар батлуулан төрийн албан хаагчид, бизнес эрхлэгчид, ААН болон төсөвт байгууллагуудын нягтлан бодогч нарт сургалтуудыг зохион байгуулсан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 60 | | 3.5.2. Татвар төлөгчдийн бүртгэл мэдээллийн зөрүүг арилган бүртгэлд хамрагдаагүй татвар төлөгчдийг бүрэн хамруулна. | 2021 2024 | -- | | Галт зэвсгийн бүртгэлийг цагдаагийн бүртгэлтэй тулган шилжүүлэг хийгдээд татварт давхар бүртгэлтэй иргэдийн бүртгэлийг хасуулж өөр сумын харъяалалтай 7 иргэнийг хасуулахаар жагсаалтыг цагдаагийн хэсэгт хүргүүлж, бүртгэлгүй 1 иргэнийг бүртгэж галт зэвсгийн бүргэл болон татварт хамруулсан. Орон сууцны зориулалттай газар үйл ажиллагаа явуулж буй 2 иргэн 1 ААН-ийг бүртгэж татварт хамруулсан. | 100% |
| 61 | | 3.5.3. Мэдээ, мэдээллийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны болон худалдан авах ажиллагааны цахим хэрэглээг иргэдэд сурталчлан таниулж, “Тунгалаг санхүү” хөтөлбөрийг хэрэгжүүлнэ | 2021 2024 | -- | | 2,4,5 дугаар багийн иргэд, албан байгууллагын албан хаагч нарт нийт 524 иргэнд мэдээ мэдээлэл хүргэж, сумын зарын группд 6 удаа байршуулсан. | 100% |
| 62 | | 3.5.4. Байгууллагуудын санхүүгийн сахилга батыг сайжруулж, ажилчдыг чадавхижуулан стандартын | 2021 2024 | -2 | | ЭМТ , Цэцэрлэг, Сургууль, ЗДТГ няравууд компьютертэй болсон. ИТХ, Соёлын ажилтангууд няравын ажлыг хавсран гүйцэтгэдэг. 6 байгууллагын нярав компьютертэй болсон байна. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | шаардлагад нийцсэн тоног төхөөрөмжөөр хангах. | | | | | |
| 63 | | 3.5.5. Төрийн өмчийн барилга байгууламж, эд хөрөнгө, техник, тоног төхөөрөмжийн хадгалалт, хамгаалалт, ашиглалтыг сайжруулан хяналт тавьж, ашиглалтын шаардлага хангахгүй болсон эд хөрөнгө, өмчийг акталж устгуулах ажлыг эрчимжүүлнэ. | 2021 2024 | -2,000,000 | | 2021 оны 04 дүгээр сард ИТХ-аас төсөвт байгууллагуудын хөрөнгөд хийсэн тооллогоор дутсан Сургуулийн пад трактор дутсан түүний төлбөрийг 2023 онд 100% төлж барагдуулсан. Аймгийн ИТХ-ын 2023.02.13-ны өдрийн 13/11 тоот тогтоол, аймгийн ИТХ-ын даргын 2023.11.13-ны 107 тоот захирамжаар хөрөнгөд эзэмшил тогтоосон хөрөнгүүдийг орлогод авсан. ЗДТГ 314,425,938.36 төгрөгийн, ЭМТ 64,062,291 төгрөгийн, Сугууль 79,842,798 төгрөгийн ИТХ 2,200,500 төгрөгийн нийт 460,531,527.36 төгрөгийн хөрөнгүүдийг аймгийн ИТХ-аар оруулж актлуулсан. Мөн 2023 оны эхэнд Бага сургууль татан буугдсан түүний 57 нэр төрлийн 71,984,490 төгрөгийн хөрөнгийг Сургууль болон ЗДТГ-т шилжүүлэн хариуцагчийг тогтоолгосон. 2023 оны 05 сард байгууллагын дарга эрхлэгч нарт засаг даргын албан тоотоор хөрөнгө тоолсон тооллогын үр дүнгийнг хэлэлцсэн тушаал ирүүлэхээр хүргүүлсэн байхад зөвхөн хөрөнгө тоолсон өмч хамгаалах зөвлөлийн хурлын тэмдэглэл ирүүлж байгаа нь ажлын үр дүнг бүрэн хэлэлцэхгүй байна гэж дүгнэж байна. | 100% |
| 64 | | 3.5.6. Өргөн хэрэглээний бараа бүтээгдэхүүний үнийг байнга барьж ажиллана. | 2021 2024 | -- | | Хүнс барааны дэлгүүрүүдэд сумын хүнс, жижиг дунд үйлдвэрлэл, хоршооны асуудал хариуцсан мэргэжилтэн Хэсгийн төлөөлөгч, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийн дарга нар хамтран лангууны үнэ кассын үнэ зөрүүтэй байгаа эсэхэд хяналт шалгалтыг 3 удаа хийсэн. Зөрүүтэй зүйл | 70% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | илрээгүй: | |
| 65 | | 3.5.7. Төсөл хөтөлбөрүүдийг судалж гадаад харилцааг идэвхижүүлэн оновчтой хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэхэд анхаарч ажиллана | 2021 2024 | -- | | | Иргэдийн хүсэлтээр уул уурхай, ашигт малтмалыг нэвтрүүлэх боломжгүй, мөн гадаад хөрөнгө оруулалтыг сум дангаараа шийдвэрлэх боломжгүй байдаг учраас уг заалт тус сумд хэрэгжих боломжгүй байна. Гадаадын зээл тусламжаар хэрэгжиж байгаа төсөл хөтөлбөр байхгүй. | 100% |
| 66 | | 3.5.8. ХАА-н цаг уурын талбайг шинэчилж, дэлхийн стандартад нийцсэн орчин үеийн цаг уурын талбайтай болж улмаар цаг уурын өртөөтэй болох | 2021 2024 | -- | | | Цаг уурын талбайг 2022 онд дэлхийн стандартад нийцүүлэн 20Х16 харьцаатай болгож иж бүрнээр шинэчилсэн. | 100% |
| Дөрөв. Засаглалын бодлогын хүрээнд: | | | | | | | | |
| 67 | 4.1.. Төрийн албаны үйлчилгээг түргэн шуурхай болгож, иргэдийг төрийн нэгдсэн бодлого удирдлагаар | 4.1.1.. Төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ажлын цаг баримтлал, үйлчлүүлэгчийн үнэлгээ, ёс зүй, | 2021 2024 | -- | | | Албан хаагдын ажлыг үнэлэхдээ албан тушаалын тушаалын тодорхойлол, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд тусгагдсан ажил үүргээ хэрхэн биелүүлснээр үнэлж ур чадварын болон үр дүнгийн мөнгөн урамшууллыг олгосон.Албан хаагчдын харилцаа хандлага, ёс зүйг үнэлэхдээ иргэдээс сэтгэл ханамжийн судалгааг авсан. Судалгаанд нийт 350 иргэн судалгаанд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хангаж, төрийн үйлчилгээг шуурхай хариуцлагатай, хүртээмжтэй хүргэх нөхцөлийг бүрдүүлж, төрийн албанд ёс зүй, чадахуйн зарчмыг төлөвшүүлж, үйл ажиллагааны ил тод байдлыг сайжруулна. | сахилга хариуцлагыг шалгуур болгож, ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагчид хүлээлгэх хариуцлагыг чангатгана | | | | хамрагдаж 2023 оны ЗДТГ-ын үйл ажиллагааны дүгнэлтээр судалгаанд оролцогчийн 82 хувь нь сайн гэсэн үнэлгээг өгсөн. Энэ онд ёс зүйн зөрчил гаргасан төрийн албан хаагч байхгүй. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийг чанд мөрдөж ажилласан. | |
| 68 | | 4.1.2.. Чадварлаг, хариуцлага, ёс зүйтэй төрийн албыг бэхжүүлнэ. | 2021 2024 | -- | | Төрийн албан хаагчдын сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх, бүтээлч санал санаачилгыг дэмжих, ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, чадавхжуулах хариуцлагатай, хүртээмжтэй төрийн албыг төлөвшүүлэх зорилгоор “Ёс зүй, хандлага зөвтэй төрийн алба-III” аяныг төрийн байгууллагуудын албан хаагчдыг хамруулан зохион байгуулсан.Засаг даргын Тамгын газрын дарга Г.Мөнхсүх Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль, Төрийн албаны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн талаар төрийн байгууллагуудын нийт 135 албан хаагчдад мэдээлэл хийсэн. Засаг даргын Тамгын газрын даргын 2023 оны 03 дугаар сарын 15-ны өдрийн А/07 дугаар тушаалаар байгуулагдсан байгууллагын “Ёс зүйн зөвлөл”-өөс Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулиар гарын авлага бэлтгэн бүх төрийн албан хаагчдад тарааж ажилласан. Үүний үр дүнд төрийн албан хаагчид сахилга, хариуцлага, ёс зүйг дээшлүүлэх уриалгад нэгдэж хуулийн мэдлэгээ нэмэгдүүлсэн. | 100% |
| 69 | | 4.1.3.. Төрийн үйлчилгээний | 2021 | -- | | Монгол улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй төрийн үйлчилгээг үе шаттайгаар цахим хэлбэрт | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | операторын үйл ажиллагааг эрчимжүүлж, төрийн байгуулагын үйл ажиллагаанд мэдээлэл харилцаа холбооны дэвшилтэт технологи, инновац нэвтрүүлэх замаар төрийн цахим үйлчилгээг нэмэгдүүлж, бүтээмж, үр ашгийг дээшлүүлнэ. | 2024 | | | шилжүүлэх Цахим хөтөлбөрийн хүрээнд E-Mongolia буюу цахим үйлчилгээний нэгдсэн системийн операторын үйлчилгээг тус сумд Засаг даргын Тамгын газарт бүрэн тоног төхөөрөмжөөр хангаж, Үйлчилгээний операторын ажилтныг томилж нэг цэгийн үйлчилгээг иргэдэд тасралтгүй хүргэж байна. Операторын хүрээнд 39 төрийн байгууллагын 440 үйлчилгээг иргэдэд хүргэх боломжтой. Операторын хүрээнд жилийн эцсийн байдлаар нийт 566 үйлчилгээг иргэдэд хүргэсэн байна. Үүнээс лавлагаа 530, нэг шатлалт үйлчилгээ 3, олон шатлалт үйлчилгээ 33, хуулийн этгээдийн 1 үйлчилгээг тус тус үзүүлсэн байна. Мөн сумын хэмжээнд emomgolia-цахим үйлчилгээний нэгдсэн системийн бүртгэлийг хийж хэрхэн ашиглах талаар заавар зөвлөгөө өгч, шинээр нэвтэрсэн үйлчилгээг сурталчлан таниулж нийт 350 иргэн болон төрийн албан хаагчдад сургалт мэдээлэл хийсэн | |
| 70 | | 4.1.4.. Мэргэжлийн болон төсөл хөтөлбөрийн байгууллагуудтай хамтран Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулж батлуулах. | 2021 2024 | -- | | Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр Сумын хөгжлийн мастер төлөвлөгөөг боловсруулах ажлын тендер зарлагдаж, сумын хөгжлийн төлөвлөгөөний боловсруулалтын ажил явагдаж байна. | 50% |
| 71 | | 4.1.5.. Төрийн байгууллагуудын | 2021 | -- | | Ерөнхий боловсролын сургуульд авто шинэчлэл | 50% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | авто парк шинэчлэлтийг хийх. | 2024 | | | хийгдсэн. | |
| 72 | | 4.1.6. Авилга ашиг сонирхолын зөрчлөөс урьдчилан сэргийлэн бүх нийтийн хандлагыг өөрчилж, сургалт сурталчилгааг эрчимжүүлнэ | 2021 2024 | -- | | Сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зөвлөл, Нийгмийн бодогын мэргэжилтэн хамтран төсөв байгууллагын албан хаагчид болон багийн ИНХ-д оролцож, Авлигын эсрэг хууль, Авлига ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулиудаар сургалт, АХА тэмцээн, хөгжөөнт тоглоом зохион байгуулсан. Сумын албан ёсны цахим хуудасны Авлигын эсрэг үйл ажиллагаа цэсэд авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөө, бусад нээлттэй байхаар заасан мэдээллүүдийг байршуулсан. Нийт 8 удаагийн сургалтаар 425 иргэнд мэдээлэл хүргэсэн. | 90% |
| 73 | | 4.1.7.. Бүх нийтийн эрх зүйн боловсролыг дээшлүүлэх тогтолцоог бэхжүүлж иргэдэд эрх зүйн харилцаанд бие даан оролцох чадварыг үе шаттайгаар нэмэгдүүлнэ. | 2021 2024 | -- | | Бүх нийтийн эрх зүйн боловсролын дээшлүүлэх үндэсний хөтөлбөрийн хүрээнд төсөвт байгууллагын албан хаагчид болон багийн ИНХ, Баялаг бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа зэрэгт шинээр батлагдсан, нэмэлт өөрчлөлт орсон хууль тогтоомж болон Хөдөлмөрийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиудаар сургалт зохион байгуулж давхардсан тоогоор 256 иргэнд хүргэсэн. Зорилтот бүлгийн иргэдэд Хөдөлмөр эрхлэлт, халамжийн мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн хамтран 3 удаагийн сургалт зохион байгуулж 75 иргэнд хүргэсэн. | 90% |
| 74 | | 4.1.7.. Хувийн | 2021 | -- | | Гал гэрэл констракшин ХХК нь гурван давхар 18 | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | хэвшлийн байгууллагуудтай хамтран төрийн албан хаагчдыг орон сууцжуулах ажлыг эхлүүлэх. | 2024 | | | айлын орон сууцыг барьж ашиглалтад оруулан төрийн албан хаагчид ипотекийн зээлд хамрагдсан. Газрын асуудлыг шийдвэрлэсэн. | |
| 75 | | 4.1.9. Шинэ сумын барилгын их засвар хийх | 2021-2024 | 80,000,000 | | Сумын орон нутгийн хөгжлийн сангийн 80,000,000 төгрөгийн хөрөнгөөр 2022 онд ОССХ ХХК шинэ сумын барилгын засварыг хийж гүйцэтгэсэн. 2023 онд аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 107,000,000 төгрөгийн засвар хийхээр “Буянт хөрс наран” ХХК хэрэгжүүлэхээр тендерт шалгараад байна. | 100% |
| 76 | | 4.1.10. Их халбагант, Баян-Ааран багуудын нутагт Жи мобайлын сүлжээ тавих. | 2021-2024 | - | | Баян-Аараг, Их халбагант багуудад Юнителийн сүлжээ энэ оны 1 дүгээр сард ашиглалтад орсон. | 100% |
| 77 | | 4.1.11.. Төрийн албаны мэргэжлийн боловсон хүчнийг бэлтгэх, хүний нөөцийг чадавхижуулах. | 2021-2024 | 1.250 | | Хөдөө аж ахуйн их сургуульд мал зүйч мэргэжлээр суралцаж байгаа Д.Мөнхбилгүүнтэй гэрээ байгуулан сургалтын төлбөрийн хөнгөлөлт үзүүлэн ажиллаж байна. | 90% |
| 78 | | 4.1.12.. Монгол улсын гавъат тамирчин Ц.Нацагдоржийн нэрэмжит болгох | 2021-2024 | - | | Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийг 2022 онд аймгийн ИТХ-ын шийдвэрээр Монгол улсын Гавьяат тамирчин Ц.Нацагдоржийн нэрэмжит болгосон. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | ажлыг эрчимжүүлж хэрэгжилтийг хангаж ажиллах | | | | | |
| 79 | 4.2.. Архивын баримтын хадгалалт хамгаалалт аюулгүй байдлыг хангаж албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулна | 4.2.1. Төрийн байгуулагуудын архивын баримтын хадгалалт хамгаалалтыг сайжруулах ажлын хүрээнд архивын баримтын нягтруулсан шүүгээтэй болсон байна. | 2021 2024 | -- | | 2001-2022 оны түр болон 70 жил хадгалах баримт, 2021, 2022 байнга хадгалах баримтуудыг бор кордонаар үдэж, баримтын хамгаалах хайрцагт хийж нягтруулсан шүүгээ болон төмөр тавиурт хадгалж байна. Засаг даргын Тамгын газар нь нягтруулсан шүүгээ 2, ЕБС 2 нягтруулсан шүүгээтэй, Эрүүл мэндийн төв 4 нягтруулсан шүүгээтэй . | 90% |
| 80 | | 4.2.2.. Албан байгууллагууд Архивын хууль бусад холбогдох журмын дагуу Төрийн архивт цаг хугацаанд нь бүрэн шилжүүлэх ажлыг эрчимжүүлж, хяналт тавин ажиллах | 2021 2024 | -- | | өрийн архив, албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагаанд мэдээллийн технологи нэвтрүүлэх үндэсний хөтөлбөр, Цахим архив-Баянхонгор дэд хөтөлбөрийн хүрээнд байгууллагын 2020 оны байнга хадгалах 142 хадгаламжийн нэгжийн 2280 хуудас баримт, нэмэлтээр тушаагдаагүй байсан 2015 оны 116 баримтын 1630 хуудас, 2016 оны 93 баримтын 1401 хуудас, 2017 оны 89 баримтын 1360 хуудас нийт 440 хадгаламжийн нэгжийн 6671 хуудас баримтыг аймгийн Төрийн архивын тасагт дансны хамт, цахим хувь үүсгэн хүлээлгэн өгсөн.Цахим шивэлтийн дүн нийт – 18265 байна.Ерөнхий боловсролын сургууль нь 2023 онд 2020 оны нийт 85 хадгаламжийн нэгжийн 874 хуудас байнга хадгалах баримт бичгийг архивын | 100% |

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | тасагт хүлээлгэн өгсөн. Цахим шивэлтийн дүн нийт – 3007 байна.Эрүүл мэндийн төв нь 2023 онд 2020 оны нийт 64 хадгаламжийн нэгжийн 727 хуудас байнга хадгалах баримт бичгийг архивын тасагт хүлээлгэн өгсөн. Цахим шивэлтийн дүн нийт – 1060 байна.Хүүхдийн цэцэрлэг нь 2023 онд 2018, 2019 оны нийт 83 хадгаламжийн нэгжийн 778 хуудас байнга хадгалах баримт бичгийг архивын тасагт хүлээлгэн өгсөн. Үүнээс 2018 оны 41 баримтын 410 хуудас, 2019 оны 42 баримтын 368 хуудас хуудас баримтыг тус тус хүлээлгэн өгсөн байна. Цахим шивэлтийн дүн нийт – 1477 байна.Соёлын төв нь 2023 онд 2020 оны нийт 44 хадгаламжийн нэгжийн 280 хуудас байнга хадгалах баримт бичгийг архивын тасагт хүлээлгэн өгсөн. Цахим шивэлтийн дүн нийт – 190 байна. | |
| Тав.. Ногоон хөгжлийн бодлогын хүрээнд: | | | | | | | | |
| 81 | 5.1.. Байгаль орчныг хамгаалах байгальд үзүүлэх сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, байгаль орчны бодлогыг төлөвлөн хэрэгжүүлнэ. | 5.1.1.. Худаг уст цэг гаргах, шаардлагатай цэгүүдэд уст цэгийн хайгуул хийх. | 2021 - 2024 | 70 сая | | 2023 онд бэлчээрийн усан хангамжийг нэмэгдүүлэхээр 2 гүний худаг гаргахаар төлөвлөн ОНХС-аас 70.0сая төгрөгийг зарцуулахаар сумын ИТХ-аар батлуулсан. Нээлттэй тендер зарлаж Чорьжбүрд компанитай гэрээ хийж тус сумын 2,4-р багийн нутагт геофизикийн хайгуулыг хийж ус гарах цэгийг тогтоосон. | 70% | |
| 82 | | 5.1.2.. Хөрсний үржил шим, чийгийг хамгаалж, газрын доройтол, хөрсний бохирдол, цөлжилтөөс | 2021 - 2024 | - | | 2022 оны 10 дугаар сарын 18- 31 хооронд Баянхонгор аймгийн Их Богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа Эрдэнэ Монгол ХХК хамтран тус сумын Улсын тусгай хамгаалалттай газар нутгуудад нөхөн сэргээлтийн ажлыг хийж гүйцэтгэсэн. 16,1 га талбайд газар нутгийг хамруулсан. | 90% | |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | сэргийлэн эвдрэлд орсон доройтсон газрыг нөхөн сэргээх. | | | | | |
| 83 | | 5.1.3.. Байгаль орчны хууль тогтоомжийг олон нийтэд сурталчилан таниулж стандарт хэм хэмжээг мөрдүүлэх | 2021 2024 | -- | | Байгаль орчны тэмдэглэлт өдрүүдийн хүрээнд иргэд, хүүхдүүдэд байгаль орчны талаарх хууль тогтоомжийн мэдлэг олгох зорилгоор Дэлхий усны өдрийг угтан Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 ангийн сурагчид болон төрийн албан хаагч нарт эрүүл мэндийн төвтэй хамтран сургалт хийсэн ба 75 сурагч хамрагдсан. Тэрбум” мод арга хэмжээний хүрээнд төрийн байгууллага, аж ахуй нэгж, иргэдэд модоо тарьж эхлүүлье уриалга гарган ажилласан. Уриалгын хүрээнд албан байгууллагууд, иргэд мод тарьж ногоон байгууламжаа нэмэгдүүлсэн. Мөн сумын зарын нэгдсэн группээр дамжуулж 1200 хүнд мэдээлэл хүргэсэн. 2023 оны 05 дугаар сарын 19 ний өдөр Монголын усны форм – Ус хэлтсийн хамт олонтой хамтран Ерөнхий боловсролын сургуулийн 8-12 дугаар ангийн сурагчид болон эко бүлгийн сурагчдад мод тарих аргачлалын талаар мэдээлэл хийж ажилласан. Нийт 250 сурагч хамрагдсан. Багийн ИНХ, Малчид төлчдийн зөвлөгөөн зэрэгт оролцож Байгаль орчны салбарт мөрдөгдөж байгаа хууль тогтоомжийн талаар иргэдэд мэдээлэл хүргэсэн. Нийт давхардсан тоогоор 450 иргэн хамрагдсан. | 100% |
| 84 | | 5.1.4.. “Хоггүй Баянлиг” аяныг зохион байгуулж хог хаягдлын | 2021 2024 | -- | | 2023 оны байдлаар сумын Засаг даргын 5 удаагийн захирамжаар 17 аж ахуйн нэгж байгууллага, 6 төрийн байгууллага, давхардсан тоогоор 215 иргэн 10.1 тонн | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | менежментийн төлөвлөгөө боловсруулан, хэрэгжилтийг хангах | | | | бүхий хог хаягдлыг түүж цэвэрлэсэн | |
| 85 | | 5.1.5.. Зэрлэг амьтадыг хамгаалах, өвс тэжээлийн хомсдлоос урьдчилан сэргийлэх, амьдрах орчныг сайжруулах чиглэлээр зэрлэг амьтны байршил бүхий газруудад био техникийн арга хэмжээ авах | 2021 2024 | -- | | Энэ жилийн хувьд зэрлэг амьтад биотехникийн арга хэмжээ авах хүнд нөхцөл үүсээгүй болно. | 100% |
| 86 | | 5.1.6.. Булгийн эхийг хамгаалах ундрагыг сэргээх ажлыг иргэд, малчид, нөхөрлөлийн оролцоотойгоор хийж хэрэгжүүлж, Булаг шанд, ус хангамжийн эх үүсвэрийн эрүүл ахуйн бүсийн | 2021 2024 | -- | | Баян-Ааргаг 2 дугаар багийн нутаг Хатавч, Бударгын булгуудын эх ундрагыг сэргээн засварлаж, булгийн эхийг тойруулан хамгаалалт хийсэн бөгөөд зэрлэг амьтад уух боломж нөхцөлийг сайжруулсан. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | дэглэмийн хэрэгжилтийг сайжруулан, хамгаалалтын бүс бий болгон шинжилгээнд хамруулах | | | | | |
| 87 | | 5.1.7.. Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын хяналтыг сайжруулах | 2021 2024 | -- | | Байгаль орчны эсрэг гэмт хэргийн чиглэлээр нийт 8 удаагийн хяналт шалгалт хийсэн бөгөөд Цагдаагийн байгууллага 2 хэргийг аймгийн Эрүүгийн цагдаагийн албанд шилжүүлж , 1 хэрэг зөрчлийг Байгаль орчны хяналтын улсын байцаагч шийдвэрлэсэн. | 100% |
| 88 | | 5.1.8.. Орон нутагт байгаа ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй компаний үйл ажиллагааг зогсоох ажлыг шийдвэрлэж, холбогдох байгууллагад уламжилж үе шаттай арга хэмжээ авах | 2021 2024 | -- | | Тусгай зөвшөөрлийг цуцлах саналыг 2021 онд холбогдох газарт уламжилсан. Одоогоор тус сумд үйл ажиллагаа эрхэлж байгаа компани байхгүй. | 90% |
| 89 | | 5.1.9.. Орон нутгийн аялал | 2021 2024 | -- | | Сумын түүхэн дурсгалт газар Цагаан агуй, Бичиг хадыг аялал жуулчлын чиглэлээр хөгжүүлж | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | жуулчлалын бизнесийг дэмжих технилогийн шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлнэ. | | | | тохижилтын үйл ажиллагаа хийгдсэн. Үүний үр дүнд бизнес эрхлэгчдийн олон талт үйл ажиллагаа нэмэгдсэн бөгөөд байнгын тогтмол үйл ажилагааг явуулж байна. | |
| 90 | | 5.1.10.. Ногоон байгууламжийг бий болгох үүднээс иргэд ААН-үүдийн дунд мод тарих хөдөлгөөнийг өрнүүлж, албан байгууллага,аж ахуйн нэгжүүд албан өрөөгөө цэцэгжүүлэн айл өрх болгон хүрээлэн буй орчиндоо ногоон байгууламжийг бий болгосон байна | 2021 2024 | -- | | Тэрбум мод үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 оны хаврын тариалалтаар 10 төрлийн 1750 мод, 3 га газарт заг сухайн үр 1250 шинээр тарьсан. 2023 онд нийт 3000 мод өөрсдийн эзэмшил талбайд тариалсан бөгөөд 150 иргэн буюу 74 өрх айл, 12 аж ахуйн нэгж байгууллага оролцсон. “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2021-2023 онд тарьсан мод тооллого ургалтын хувийг тогтоох ажлыг сумын Засаг даргын захирамжаар ажлын хэсэг байгуулж модны ургалтын хувийг тогтоосон. 2021-2023 онд нийт 35600 мод тарьснаас 32800 мод ургасан.Ургалтын хувь 92,1 хувьтай байна. | 100% |
| 91 | | 5.1.11. Сумын хэмжээнд ААН, айл өрхүүдийг стандартын муу усны цооног, нойлтой болгож, холбогдох | 2021 2024 | -- | | Цагдаагийн байгууллага, Эрүүл мэндийн төвтэй хамтран 3 удаагийн хяналт шалгалт хийж, шаардлага хүргүүлэн ажилласан. Сумын хэмжээнд 2023 оны байдлаар нийт 7 өрх айл нойл, муу усны цооногийг шинээр барьж, 2 аж ахуйн нэгж байгууллага нойлоо шинэчилсэн. | 90% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байгууллагууд, мэргэжилтнүүд хамтран хяналт тавих ажлыг эрчимжүүлж ажиллах (ЭМТ, Байгаль орчин, Цагдаагийн хэсэг, 5 дугаар багийн Засаг дарга) | | | | | |
| 92 | 5.2. Газар зохион байгуулалт, төлөвлөлт | 5.2.1. Газар зохион байгуулалтын төлөвлөлтийг эмх цэгцтэй, бодит байдлаар хийж, гэр хорооллын дахин төлөвлөлтийн хүрээнд "Жишиг гудам" бүхий арга хэмжээг авч хэрэгжүүлэх | 2021 2024 | -- | | Жишиг гудам арга хэмжээнд “нарлаг хороолол”-ыг төлөвлөсөн. Нарлаг хороололд 23 айлтай бөгөөд тус хорооллын бүх айл халуун дулаанд холбогдсон. Ихэнх айлууд хашаандаа мод тарьсан. | 70% |
| Зургаа. Амар тайван, аюулгүй нийгмийн бодлогын хүрээнд | | | | | | | |
| 93 | 6.1. Иргэдийн амар тайван байдлыг хангах | 6.1.1. Сумын хэмжээнд гарч буй гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан, нөхцөлийг | 2021 2024 | -- | | Сумын хэмжээнд 2023 онд гэмт хэрэг зөрчлийн нийт 18 гомдол мэдээлэл бүртгэгдсэнээс согтуугаар үйлдсэн зөрчил 8 бүртгэгдэж өмнөх оны мөн үеэс буурсан үзүүлэлттэй байна. Архидан согтуурахтай тэмцэх чиглэлээр архи согтууруулах ундаа хэрэглэхгүй байх талаар сумын ГХУСАЗСЗ-тэй | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | тогтоон, урьдчилан сэргийлж хяналтыг сайжруулах | | | | хамтран 2 удаагийн сургалт мэдээллийг хийж, жагсаалт гарган гарын үсэг зуруулан баталгаа авч ажилласан. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 295 айл өрхөөр орж, 601 ширхэг гарын авлага тарааж ажилласан. Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 6-12 дугаар багийн сурагчид болон дотуур байрны 85 сурагчдад цахим гэмт хэрэг, хүүхдийн эрх чөлөөнд халдах гэмт хэргийн талаар сургалт мэдээлэл хийсэн. Мөн сумын зарын группт мэдээлэл анхааруулгыг 16 удаа оруулж ажилласан. | |
| 94 | | 6.1.2. Цагдаагийн албан хаагчдын ажиллах, амьдрах орчин нөхцөлийг сайжруулах | 2021 2024 | -- | | Шинэ сумын төвийн барилгад 3 өрөөг Цагдаагийн хэсэг болгон тохижуулж ажиллах нөхцөл боломжоор хангасан. Цагдаагийн кубоныг тохижуулан амьдрах орчин нөхцөлөөр бүрэн хангасан. | 100% |
| 95 | | 6.1.3. Малчдын бүлгэмийг шинэчлэн байгуулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх, хамтран ажиллах | 2021 2024 | -- | | Тус сумд мал хулгайлах гэмт хэрэг гардаггүй учраас малчдын бүлгэмийг байгуулаагүй. Сумын ГХУСАЗСЗ, Цагдаагийн хэсэг ард иргэдэд малыг байнгын хариулгатай байлгаж, хараа хяналтаа сайн тавьж, хөрш зэргэлдээ аймаг орон нутагт отор нүүдлээр ирж байгаа малчин иргэдэд сэрэмжтэй байх, хашаа, хороогоо тогтмол эргэж, тойрч байх энэ чиглэлээр гарын авлага тарааж ажилласан. Мөн сумын төвөөр дамжин өнгөрч буй мал ачиж буй тээврийн хэрэгслүүдийг тогтмол шалгаж гарал үүслийн бичигтэй эсэх болон тухайн орон нутгийн мал эмнэлгийн эмчийн кодтой эсэхийг нь тулгаж бүртгэл судалгаанд авч ажилласан. | 90% |
| 96 | | 6.1.4. Осол | 2021 | -- | | 5 газрын замыг хааж, 2 газарт хурд сааруулагч, 10 | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | гэмтлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр замын тэмдэг, тэмдэглэгээ нэмэгдүүлэх | 2024 | | | газарт тэмдэг тэмдэглэгээ, байгууллагуудын гадна талбайд зогсоолын тэмдэг байршуулсан. | |
| 97 | | 6.1.5. Сумын хэмжээний архины хамааралтай иргэдийг соён гэгээрүүлэх үүднээс "Жаргалтай амьдрал төв"-тэй хамтран ажиллах | 2021 2024 | -- | | Архи, согтуурулах ундаа байнга хэрэглэдэг иргэн И.Доржбатыг Жаргалтай амьдрал төвд" зуучлан эмчилгээнд хамруулсан. Мөн Аймгийн гэр бүл хүүхэд залуучуудын хөгжлийн газартай хамтран зохион байгуулсан "Амар тайван гэр бүл" нэгдсэн өдөрлөгт архины хамааралтай гишүүнтэй 3 гэр бүлийн гишүүдэд мэргэжлийн сэтгэзүйчийн зөвлөгөөнд хамруулж сэтгэл зүйн дэмжлэг үзүүлсэн. Цагдаагийн хэсэгтэй хамтран архины хор хөнөөл, аюул ослын талаар бичлэг мэдээллийг багийн иргэдийн нийтийн хурал дээр сургалт хийж ажилласан. | 90% |
| 98 | | 6.1.6. Гэр бүлийн хүчирхийллийн улмаас үйлдэгдэж буй гэмт хэрэг зөрчлийн тоог бууруулж, урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах | 2021 2024 | -- | | Сумын гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг, үйлдэж болзошгүй иргэдийн судалгааг гаргасан.“Малчид, төлчдийн зөвлөгөөн”-д оролцсон нийт 184 иргэд болон “Баялагч бүтээгчдийн үзэсгэлэн худалдаа”-нд оролцсон 50 гаруй иргэд, мөн Ерөнхий боловсролын сургуулийн 12 дугаар ангийн 27 сурагч, 11 дүгээр ангийн 25 сурагч, 10 дугаар ангийн 25 сурагчдад “Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх аргууд” сэдэвт сургалтыг хийсэн. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 5 кейс нээн Хамтарсан багаараа төлөвлөгөө гарган хэрэгжүүлж ажилласан. Төлөвлөгөөний хэрэгжилт 80 хувьтай. Өмнөх онтой харьцуулахад гэр бүлийн хүчирхийлэл энэ онд | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 16.7%-иар буурсан байна. | |
| 99 | | 6.1.7. Тодорхой цэгүүдийг теле камерийн хяналтад авах ажлыг үе шаттайгаар нэмэгдүүлэх | 2021 2024 | -- | | Сумын төвийн камеруудын засвар үйлчилгээг явуулж, шинээр камер суурилуулсан. Эдгээр камер нь сумын төвийг бүхэлд харах бөгөөд ингэснээр гэмт хэрэг, зөрчил тодорхой хэмжээгээр буурах тухай бүрд нь илрүүлэх боломж нөхцөл бүрдсэн. Хавсралт : 2 зураг | 100% |
| 100 | | 6.1.8. Мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх, таслан зогсоох, холбогдох байгууллагуудтай хамтран бүх талын арга хэмжээг авч ажиллах | 2021 2024 | -- | | Сумын нийт багуудын нутаг дэсвгэрт мал хулгайлах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр 295 айл өрхөөр орж, 601 ширхэг гарын тарааж ажилласан. Сумын хэмжээнд мал мах худалдан борлуулдаг иргэд, хоршоодын үйл ажиллагаанд хяналт тавьж санамж зөвлөгөө өгч судалгаанд бүртгэл хийж хууль бусаар ан агнуур хийсэн гэх дуудлага мэдээлэлд эргүүл шалгалтад хийж ажилласан. Мөн сумын хөдөлгөөн ихтэй газар 2 самбар байршуулсан. Энэ онд Мал хулгайлах гэмт хэрэг бүртгэгдээгүй. | 100% |
| 101 | 6.1. Иргэдийн амар тайвар байдлыг хангах | 6.1.9. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөлийг шинэчлэн байгуулж, хүнсний аюулгүй байдлыг ханган, чанар байдалд | 2021 2024 | -- | | Сумын хүнс, барааны дэлгүүр цайны газраар сумын хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах зөвлөл, цагдаагийн хэсэгтэй хамтран бараа бүтээгдэхүүний чанар болон хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах зорилгоор хяналт шалгалтыг 3 удаа зохион байгуулж ажилласан. Хяналт шалгалтаар найман нэр төрлийн бараа бүтээгдэхүүний хугацаа дууссан байсныг газар дээр нь устгалд оруулж зөрчил гаргасан дэлгүүрүүдэд зөвлөмж хүргүүлж ажилласан. | 100% |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | байнгын хяналт тавьж ажиллах | | | | Хавсралт : 2 зураг | |

.....................oOo.....................